

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал

Тэмээ	- 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал	- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу- Өмнөх оны төл,	2 настай
Үхэр- Өмнөх оны төл	

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25	Азарга -	12-15
Бух -	35-45	Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Тариалангийн талбай . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Оршил

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2013 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2013 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Малтай өрх, малчдын тоо. Аймгийн хэмжээгээр 2013 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 7.1 мянган өрх тоологдсон байна. Үүний 80.3 хувь буюу 5.7 мянган өрх нь жилийн 4 улирлын турш малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 19.7 хувь нь буюу 1.4 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2013 оны мал тооллогын дүнгээр 10.9 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 35.7 хувь нь 15-34 насны, 52.5 хувь нь 35-59 насны, 11.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

2013 оны байдлаар нийт малчин өрх, малчдын тоо буурах хандлагатай байна.

Малчин өрхийн зарим үзүүлэлт 2013 оны байдлаар

Сумд	Өрхийн тоо	Ам бүлийн тоо	Малчдын тоо	Эмэгтэй малчдын тоо	Малчид насны бүлгээр		
					15-34 насны	35-39 насны	60 ба түүнээс дээш
Сайнцагаан	636	2296	1156	543	367	656	133
Адаацаг	498	1917	973	464	353	527	93
Баянжаргалан	187	550	322	142	120	153	49
Говь-Угтаал	245	816	445	203	157	248	40
Гурвансайхан	386	1359	736	353	254	393	89
Дэлгэрхангай	304	1106	597	273	204	323	70
Дэлгэрцогт	305	945	541	259	215	233	93
Дэрэн	368	1355	746	335	243	380	123
Луус	301	1159	598	267	225	334	39
Өлзийт	408	1384	788	365	293	407	88
Өндөршил	194	694	386	174	158	204	24
Сайхан-Овоо	303	1210	601	286	247	315	39
Хулд	328	1232	663	305	240	352	71
Цагаандэлгэр	220	580	348	154	98	197	53
Эрдэнэдалай	1016	3654	2038	1010	735	1023	280
Нийт	5699	20257	10938	5133	3909	5745	1284

Малын тоо. 2013 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1996.3 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 324.3 мянган толгойгоор буюу 19.4 хувиар өслөө. Малын төрлөөр авч үзвэл тэмээ 8.4 хувь, адуу 18.1 хувь, үхэр 29.1, хонь 18.9 хувь, ямаа 20.0 хувиар тус тус өссөн байна. Тооллогоор тэмээ 24.9 мянга, адуу 85.0 мянга, үхэр 35.6 мянга, хонь 922.3 мянга, ямаа 928.4 мянган толгой нийт 1996.3 мянган мал тоологдов.

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Малын тоо, төрлөөр /мян.тол/

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
									хувь	зөрүү
Тэмээ	19.7	19.8	19.9	20.7	18.9	19.7	23.0	24.9	108.3	1.9
Адуу	107.3	104.7	84.0	82.0	51.3	59.7	72.0	85.0	118.1	13.0
Үхэр	40.3	42.6	34.2	33.7	18.6	21.0	27.6	35.6	129.0	8.0
Хонь	867.1	944.3	917.9	973.8	529.7	623.4	775.8	922.3	118.9	146.5
Ямаа	870.7	998.2	984.6	1,036.9	493.0	624.9	773.6	928.4	120.0	154.8
Бүгд	1,905.1	2,109.6	2,040.6	2,147.1	1,111.5	1,348.7	1,672.0	1,996.3	119.4	324.3

Жилийн өсөлтөөс харахад тэмээ 8.3 хувиар өссөн байгаа нь хамгийн бага, үхэр 29.0 хувиар өссөн байгаа нь хамгийн их байгаа юм. Нийт малын дүнд сумдын малын эзлэх хувийн жинг авч үзвэл Эрдэнэдалай 15.3 хувь, Сайнцагаан 10.4 хувь, Гурвансайхан 8.2 хувь, Адаацаг, Өлзийт 7.5 хувийг тус тус эзэлж байна. Малаа өсгөж 1000-аас дээш мал тооллуулсан 269 өрхийн 348922 толгой мал байна. Энэ нь нийт малын 17.5 хувийг эзэлж байна. Эрдэнэдалай сумын малчин Н.Лхасүрэн 3137 толгой мал тоолуулж аймгийн хэмжээнд хамгийн олон малтай өрхөөр тодорсон бөгөөд үүнээс адуу 501 толгой, үхэр 185 толгой, хонь 1806 толгой малаар, харин тэмээгээр Өлзийт сумын малчин Б.Насан 437 толгой, ямаагаар Дэлгэрцогт сумын малчин Ж.Батмөнх 1008 толгой малаар тус тус тэргүүлж байна.

Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 1.2 хувь, адуу 4.3 хувь, үхэр 1.8 хувь, хонь 46.2 хувь, ямаа 46.5 хувийг тус тус эзэлж байна

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

Бүгд	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	1.1	1	0.9	1	1	1.7	1.5	1.4	1.2
Адуу	6.5	5.7	5	4.1	3.8	4.6	4.4	4.3	4.3
Үхэр	2.4	2.1	2	1.7	1.6	1.7	1.6	1.6	1.8
Хонь	44.8	45.5	44.8	45	45.3	47.7	46.2	46.4	46.2
Ямаа	45.2	45.7	47.3	48.2	48.3	44.4	46.3	46.3	46.5

2013 оны байдлаар авч үзвэл бог малын 49.8 хувийг хонь, 50.2 хувийг ямаа эзэлж байна. Бог малд хонь 75.0 хувь орчим, ямааны эзлэх хувь 25.0 хувь орчим байвал сүргийн бүтцэд болон малын бэлчээрт зохистой байдаг гэсэн уламжлалт харьцаа алдагдсаар байна.

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Мал тооллогын 2013 оны дүнгээр нийт мал болон адуу, үхэр, хонь ямаагаар Эрдэнэдалай, тэмээгээр Өлзийт сум тэргүүлж байна.

Хэдийгээр ургамлын гарц тачир, усан хангамжийн хүрэлцээ муутай ч манай аймгийн нутагт ашиглавал зохих бэлчээр газар, нутаг хангалттай байна. Энэ утгаар нь авч үзвэл Дундговь аймагт мал сүргийг махны чиглэлээр эрчимжүүлэн өсгөн үржүүлэх бололцоотой юм.

Хонины мах, гүүний айрагны амт чанараар нэрд гарсан манай аймгийн хувьд төвийн бүсийн тодорхой оршин суугчдыг мах, махан бүтээгдэхүүнээр хангах нөөц боломж үндэслэл байгаа болно. Ер нь эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх нь хөгжлийн 2 дахь нөхцөл болно гэж үзэж байна.

Хувийн малын тоо. 2013 онд хувийн малын тоо 1990.7 мянган толгойд хүрч нийт малын 99.7 хувийг эзэлж байна. Тэмээний 99.6 хувь, адууны 99.9 хувь, үхрийн 99.7 хувь, хонины 99.8 хувь, ямааны 99.7 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо 2012 оныхоос 330.5 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

Хээлтэгч мал. 2013 оны эцэст 817.8 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 18.6 хувь буюу 128.4 мянгаар 5 төрөл дээрээ өссөн байна. Хээлтэгч мал нийт сүргийн 41.0 хувь, үүнээс тэмээний 38.4 хувийг ингэ, адууны 29.3 хувийг гүү, үхрийн 38.8 хувийг үнээ, хонины 43.0 хувийг эм хонь, ямаан сүргийн 40.2 хувийг эм ямаа эзэлж байна.

Хээлтэгч малын тоо

/мян.тол/

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
									хувь	зөрүү
Ингэ	6.5	6.9	7.2	7.3	7	7.6	8.9	9.6	107.9	0.7
Гүү	31.9	31.2	26.7	25.1	17.7	18.9	21.6	24.9	115.3	3.3
Үнээ	16.9	18.1	15.1	14.9	8.3	9.5	11.4	13.8	121.1	2.4
Эм хонь	379.8	401.8	406.4	413.1	266.2	267.3	334.2	396.5	118.6	62.3
Эм ямаа	372.9	402.5	427.9	418.6	259.7	250.9	313.3	373	119.1	59.7
Бүгд	808	860.5	883.3	879	558.9	554.2	689.4	817.8	118.6	128.4

Төл бойжилт. Аймгийн хэмжээгээр оны эхний төллөвөл зохих 689.4 мянган эх малаас 690.8 мянган төл бойжуулан авав. Бойжуулсан төлийн тоо өмнөх оныхоос 136.3 мянгаар өссөн байна. Гарсан төлийн 99.7 хувь нь бойжсон байна.

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Төл бойжилт / мян.толгой/

Он	Бүгд						Үүнээс: (2013 он)				
	2008	2009	2010	2011	2012	2013	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	631.9	760.6	298.3	486.5	556.6	693.1	4.2	19.6	11.1	338.2	320.0
Бойжсон төл	564.2	724.8	187.5	481	554.3	690.8	4.2	19.5	11.1	337.3	318.7
Бойжилтын хувь	89.3	95.3	62.9	495.3	99.9	99.7	100.0	99.5	100.0	99.7	99.6

Том малын зүй бус хорогдол. Энэ онд оны эхний малын 0.3 хувь буюу 4.3 мянган том мал хорогдов. Үүний дотор оны эхний тэмээний 0.1 хувь, адууны 0.1 хувь, үхрийн 0.2 хувь, хонины 0.2 хувь, ямааны 0.3 хувь нь хорогджээ. Хулд, Эрдэнэдалай сумдад малын хорогдол гараагүй байна.

Том малын зүй бус хорогдлын 6.9 хувь буюу 298 нь өвчнөөр, 18.4 хувь буюу 624 нь хээлтэгч мал байна. Зүй бусаар хорогдсон том малын тоонд алдсан мал ороогүй болно.

Том малын зүй бус хорогдол

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Тэмээ	160	44	117	51	1,151	16	21	23
Адуу	2,600	1,154	7,606	1,534	21,195	151	114	78
Үхэр	1,920	251	3,817	677	13,007	68	48	65
Хонь	20,607	2,167	20,300	13,914	377,618	1,838	1,639	1,848
Ямаа	24,366	2,338	25,399	18,823	465,255	2,251	1,709	2,312
Бүгд	49,653	5,954	57,239	34,999	878,226	4,324	3,531	4,326

Малын хээл хаялт, сувайралт. 2013 онд оны эхний хээлтэгч малын 3.8 хувь буюу 30.9 мянга нь төл өгөөгүй хээлтэгч байгаа ба энэ нь өмнөх оныхоос 2.2 хувиар буюу 0.7 мянган толгойгоор буурсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын 96.3 хувь нь сувайрч, 3.7 хувь нь хээл хаясан байна. Нийт төл өгөөгүй хээлтэгч малын 44.0 хувийг эм хонь, 45.4 хувийг эм ямаа эзэлж байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо

Он	Сувайрсан					Хээл хаясан				
	2009	2010	2011	2012	2013	2009	2010	2011	2012	2013
Ингэ	225	476	5	130	109	13	56	145	6	3
Гүү	7,321	7,454	95	2,595	2,213	858	2,614	3,195	83	65
Үнээ	3,456	3,229	42	897	856	375	652	2,091	20	17
Эм хонь	26,491	83,168	588	13,192	13,222	3,877	18,289	21,769	810	375
Эм ямаа	30,034	64,326	1,966	12,443	13,348	11,183	74,348	21,414	1,463	668
Бүгд	67,527	158,653	2,696	29,257	29,748	16,306	95,959	48,614	2,382	1,128

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. 2013 онд 16.5 мянган хээлтүүлэгч мал тоологдож, өмнөх оныхоос 1.4 мянган толгойгоор буюу 9.2 хувиар өсчээ. Аймгийн дүнгээр бууранд 40 ингэ, азарганд 8 гүү, буханд 29 үнээ, хуцанд 61 эм хонь, ухнанд 61 эм ямаа тус тус ногдож байна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой гэж үздэг ч 2013 онд аймгийн дунджаар 61 эм хонь, ямаа ногдож 2 дахин илүү өндөр үзүүлэлт гарч байна.

2013 оны байдлаар хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

Сумд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Сайнцагаан	25	9	28	71	67
Адаацаг	30	8	30	58	60
Баянжаргалан	26	6	26	58	56
Говь-Угтаал	102	8	36	59	56
Гурвансайхан	29	8	35	69	58
Дэлгэрхангай	30	8	29	52	66
Дэлгэрцогт	30	9	38	64	64
Дэрэн	30	9	37	61	59
Луус	46	8	30	58	58
Өлзийт	39	7	18	75	71
Өндөршил	37	9	30	81	71
Сайхан-Овоо	27	8	19	32	50
Хулд	34	9	22	63	62
Цагаандэлгэр	96	8	33	60	59
Эрдэнэдалай	26	8	25	60	57
Аймгийн дундаж	40	8	29	61	61

Малын хэрэглээний зарлага. 2013 онд оны эхний нийт малын 20.0 хувьтай тэнцэх 317.0 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 46.6 хувийг хонь, 48.9 хувийг ямаа, 4.5 хувийг бод мал эзэлж байна. 2013 онд оны эхний тэмээний 9.6 хувь, адууны 8.9 хувь, үхрийн 14.6 хувь, хонины 20.8 хувь, ямааны 18.4 хувийг хэрэглээнд зарцуулжээ. Энэ онд зах зээлд худалдан борлуулсан малын тоо өмнөх оноос 55.7 мянгаар өсч 201.1 мянга болсон байна.

Малын хэрэглээний зарлага

/мян.толгой/

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Тэмээ	3.2	2.6	3	2.5	3	1.9	2	2.2
Адуу	18.5	16.2	18.6	14.5	12.5	5.8	5.5	6.4
Үхэр	9.5	8.6	10.2	9.1	6.2	3.5	3.5	4
Хонь	179.7	204.7	235.6	235.3	154	107.1	120.8	161.7

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

Ямаа	147.4	159.6	191.9	225.3	125.8	87.6	114.6	142.7
Бүгд	358.3	391.7	459.3	486.7	301.7	205.9	246.4	317

Малын бүлэглэлт. 2012 оны иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл нийт малтай өрхийн 30.8 хувь нь 100 хүртэл малтай, 22.4 хувь нь 101-200 малтай, 30.1 хувь нь 201-500 малтай, 13.0 хувь нь 501-1000 малтай, 3.7 хувь нь 1000-аас дээш малтай байна.

Аймгийн дунджаар мал бүхий нэг өрхөд (бодод шилжүүлснээр) 60 бод, толгойн тоогоор 282 мал ногдож байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

2013 оны малчин өрхийн малын бүлэглэлт

Сумд	Бүгд	50 хүртэл малтай	51-100 малтай	101-200 малтай	201-500 малтай	501-999 малтай	1000 аас дээш малтай
Сайнцагаан	636	92	83	139	214	79	29
Адаацаг	498	45	83	117	181	56	16
Баянжаргалан	187	12	16	30	58	53	18
Говь-Угтаал	245	12	22	32	89	60	30
Гурвансайхан	386	35	37	61	135	83	35
Дэлгэрхангай	304	47	44	114	80	17	2
Дэлгэрцогт	305	49	42	76	101	25	12
Дэрэн	368	40	44	68	128	68	20
Луус	301	20	25	73	128	51	4
Өлзийт	408	31	51	78	150	80	18
Өндөршил	194	4	8	28	67	61	26
Сайхан-Овоо	303	35	35	92	108	28	5
Хулд	328	12	23	70	147	69	7
Цагаандэлгэр	220	23	29	53	73	31	11
Эрдэнэдалай	1016	157	122	249	318	136	34
Дүн	5699	614	664	1280	1977	897	267

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 33.9 хувь буюу 677.3 мянга нь төл, 1.6 хувь буюу 32.9 мянган өсвөр насны мал, 41.0 хувь буюу 817.8 мянга нь хээлтэгч, 22.6 хувь нь буюу 451.8 мянга нь нас гүйцсэн эр мал, 0.8 хувь буюу 16.5 мянга нь хээлтүүлэгч байна.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 2013 онд тоологдсон цэвэр, үүлдвэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн 10143 мал байна. Үүнээс тэмээ 362 буюу 3.6 хувь, адуу 390 буюу 3.8 хувь, үхэр 724 буюу 7.1 хувь, хонь 5241 буюу 51.7 хувь, ямаа 3426 буюу 33.8 хувийг эзэлж байна.

Малчдын нийгэм ахуйн зарим үзүүлэлт. 2013 оны байдлаар нийт малчин өрхийн дотор 4723 өрх буюу 82.9 хувь нь цахилгаан эх үүсгэвэртэй, 4220 өрх буюу 74.0 хувь нь телевизортой, 2398 өрх буюу 42.1 хувь нь авто машинтай, 3348 өрх буюу 58.7 хувь нь мотоциклтэй, давхардсан тоогоор 8292

өрх буюу 145.5 хувь нь гар утастай байна. Цахилгаан эх үүсвэртэй өрхийн тоо өмнөх оныхоос 353 буюу 8.1 хувь, телевизортой өрхийн тоо 78 буюу 1.8 хувь, автомашинтай өрхийн тоо 329 буюу 15.9 хувиар тус тус өссөн байна.

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 4399 буюу 93.1 хувь нь нарны, 146 буюу 3.1 хувь нь салхины, 73 буюу 1.5 хувь нь бусад (бага оврын мотор, акумулятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байгаа бол цахилгааны төвлөрсөн системд холбогдсон малчин өрх 105 байгаа нь нийт малчин өрхийн 2.3 хувийг эзэлж байна.

Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл. Монгол Улсын Засгийн газрын Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нилээдгүй хөрөнгө, мөнгийг зарцуулж байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, гадаад улс орон, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

**Малжуулах арга хэмжээнд хамрагдсан
өрх, ам бүл, малын тоо**

	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан											
	Өрхийн тоо				Ам бүлийн тоо				Малын тоо			
	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
Дүн	367	194	196	228	1475	778	741	899	7934	4531	7967	8019

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 32 өрхөөр буюу 16.3 хувиар өссөн байна.

Малжуулах арга хэмжээгээр 228 өрхөд нийт 8.0 мянган толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 95.9 хувь нь бог мал, 4.1 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 35 толгой мал олгосон байна.

**Малжуулах арга хэмжээнд
зарцуулсан хөрөнгийн тайлан**

Он	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая.төг	Үүнээс: (2013 он)		
		Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө мян.төг	Орон нутгийн хөрөнгө мян.төг	Бусад мян.төг

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

	2008	2009	2010	2011	2012	2013			
ДҮН	141.8	72.7	303.3	210.3	480.3	1032	33000	372161	627201

Шинээр гаргасан, засварласан худаг. Монгол Улсын Засгийн газраас усны нөөцийн эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг, уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

2013 онд 21 худаг шинээр ашиглалтанд орсноос бүгд инженерийн хийцтэй худаг байна.

Шинээр гаргасан худгийн тоо

Он		2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Шинээр гаргасан худгийн тоо, бүгд		61	56	42	56	28	33	59	21
Үүнээс:	Инженерийн хийцтэй	16	44	27	17	17	30	55	21
	Энгийн уурхайн	45	12	15	39	11	3	4	-

Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө

Он	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая төг						Үүнээс: /2013 он, сая төг/		
							Улсын төсвийн хөрөнгөөр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
	2008	2009	2010	2011	2012	2013			
Дүн	62.3	245.1	208.5	379.1	877.0	289.5	287.3	-	2.2

ГАЗАР ТАРИАЛАН

Тариалсан талбай. Аймгийн хэмжээгээр 2013 онд нийт 53.0 га-д тариалалт хийсэн нь 2012 оныхоос 7.7 га-аар буюу 12.7 хувиар буурчээ.

2013 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл 38.3 га-д төмс, 14.7 га-д хүнсний ногоо тариалсан нь өнгөрсөн оноос төмс 16.0 хувь буюу 7.3 га-аар, хүнсний ногоо 2.6 хувь буюу 0.4 га-гаар тус тус буурчээ.

Газар тариалангийн үйлдвэрлэл, хураасан

ургац

Он	Хураасан ургац тонн	2013/2012
----	---------------------	-----------

Дундговь аймгийн статистикийн хэлтэс

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	Хувь	зөрүү
Төмс	79.3	84.3	219.8	460.4	304.5	174.4	121.2	123.4	101.8	2.2
Хүнсний ногоо	60.4	56.8	46.2	73.2	48.7	34.5	29.6	31.9	107.8	2.3
Хадлан	350.0	360.0	358.0	230.0	239.0	107.0	45.0	35.0	77.8	(10.0)
Гар тэжээл	4,721.8	1,349.5	4,638.5	890.4	3,839.0	4,099.8	2,447.5	3,850.0	157.3	1,402.5

2013 онд аймгийн хэмжээнд 123.4 тонн төмс, 31.9 тонн хүнсний ногоо хураан авч, 3850.0 тонн гар тэжээл үйлдвэрлэж, 35.0 тонн байгалийн хадлан бэлтгэсэн байна.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. Монгол улсын статистикийн эмхтгэл 2009, 2010, 2011, 2012, 2013
2. Аймгийн статистикийн мэдээний танилцуулга 2010, 2011, 2012, 2013
3. Жилийн эцсийн мал тооллогын материал 2013 он



Материалыг бэлтгэсэн: Ж.Уянга

Хянасан: Н.Түвшинжаргал

Утас: 7059 3715, 99279031

2014 оны 04 р сарын 02

ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС